САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ СТРАТЕГИ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Орхон аймаг

| Д/д | Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги /арга зам/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2023 он/ | Хүрсэн түвшин | Биелэлт -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| ***Ерөнхий чиг үүрэг-1:*** *Олон Улсын дотоод аудитын тогтолцоог төлөвшүүлэх* | | | | | | |
| ***Үндсэн чиг үүрэг-1:*** *Дотоод аудитын бие даасан, хараат бус байдлыг дээшлүүлэх* | | | | | | |
| 1 | **Зорилт-1** Хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын үйл ажиллагаанд бусад холбогдох дүрэм, журмыг боловсруулж, батлах | **Арга хэмжээ-1** Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журам шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлтийг тухай бүр боловсруулан батлуулах | Шинэчлэн батлагдсан хууль тогтоомж | Хөдөлмөрийн дотоод журам болон Нэгдсэн менежментийн тогтолцоонд нийцүүлэн холбогдох стандарт үйл ажиллагааны журмуудад өөрчлөлт орсон. | 1. Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор албаны нэршил өөрчлөгдсөн, Сангийн сайдын 2019 оны 268 тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал” шинээр батлагдсантай уялдуулан Аймгийн Засаг даргын А/233 дугаар захирамжаар баталсан “*Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрэм*”, “*Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх журам*”-д нэмэлт өөрчлөлтийг тусган Аймгийн Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн “*Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм*”, “*Дотоод аудит хийх журам*”, “*Санхүүгийн хяналт шалгалт хийх журам”*-ыг тус тус батлуулан мөрдөж байна.<br>2. Нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилтэд олон улсын стандарт баталгаажуулалтын “МонСертф” ХХК-ийн Олон улсын тэргүүлэх аудитор Ю.Наранцацрал, Олон улсын тэргүүлэх аудитор Н.Мэндбаяр нар 2024.09.27-ны өдөр албанд ажиллаж, Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандартын давтан аудит, | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2016 Олон улсын стандартын магадлах 2 аудитыг тус тус хийж гүйцэтгэлээ. Аудитаар Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандартын давтан аудитаар 62 шалгуур үзүүлэлт, Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2016 Олон улсын стандартын магадлах 2 аудитаар 44 шалгуур үзүүлэлт нийт 106 шалгуур үзүүлэлтээр дүгнүүлж, аудитад амжилттай хамрагдсан.<br>3. Албаны үйл ажиллагаанд мөрдөж буй Стандарт үйл ажиллагааны 13 журам, 2 гарын авлагыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | |
| 2 | **Зорилт-2** Дотоод аудитыг хэрэгжүүлж, бусад байгууллагатай хамтран ажиллах | **Арга хэмжээ-1**<br>Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Сангийн яаманд хуулийн хугацаанд тайлан мэдээг хүргүүлэх | “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.9- дэх заалт | Өөрчлөлт орсон бүтцийн бүрэлдэхүүнийг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн батласан. | Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу эхний хагас жилийн тоон мэдээ, бичмэл тайланг 2024.07.09-ний өдрийн 131 дугаартай албан бичгээр Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлж ажилласан.<br>Жилийн эцсийн тайланг Сангийн яамнаас ирсэн чиглэлийн дагуу 2025.01.10-ны өдрийн дотор хүргүүлнэ. Хугацаа болоогүй байна. | 100% |
| 3 | | **Арга хэмжээ-2**<br>”Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн дагуу үйл ажиллагаа явуулж, хурлаар хорооны бүтэц, дотоод аудитын жилийн төлөвлөгөө болон бусад холбогдох асуудлыг шийдвэрлэн тогтоол, шийдвэрийн | ”Дотоод аудитын хорооны дүрэм”, Дотоод аудитын хорооны тогтоол, Байгууллагын Эрсдэлийн үнэлгээний | Эрсдэлийн мэдээллийн сангаас эрсдэлээр нь эрэмбэлж сонгосон. | Сангийн яам болон аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Орхон аймаг дахь Төрийн аудитын газар болон орон нутгийн улсын төсөвт байгууллагуудын дээд шатны байгууллагуудтай албан бичгээр тайлан, мэдээ, саналыг тухай бүр хүргүүлж, үр дүнтэй хамтын ажиллагааг эрхэмлэн хамтран ажилласан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтийг хагас,бүтэн жилээр холбогдох газарт хүргүүлэх, тайлагнах | журам, эрсдэлийн үнэлгээ | | | |
| 4 | | **Арга хэмжээ-3** Бусад төрийн захиргааны төв байгууллагатай хяналт шалгалтын чиглэлээр хамтран ажиллах | Шийдвэрийн тоо | Холбогдох дээд шатны байгууллагууда д мэдээ, тайлан судалгааг тогтоосон хугацаанд хүргүүлж хамтран ажилласан. | 2024 оны “Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө”-нд аймгийн Соёл урлагийн газар, Орхон-АЗЗА ТӨХК, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар зэрэг 6 байгууллагад-Санхүүгийн хяналт шалгалт хийх хүсэлтийг Эрүүл мэндийн яам, Соёлын яам, Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Зам тээврийн яаманд тус тус хүргүүлж ажиллалаа.<br>Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын санхүү үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгэх саналыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, албан бичгээр хүргүүлж ажиллалаа.<br>Эдгээр байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийг үндэслэн “2024 оны дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө”-нд тусган батлуулж, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэн дээд шатны байгууллагуудад тайлан, дүгнэлтийг албан бичгээр хүргүүлэн хамтран ажилласан. | 100% |
| 5 | **Зорилт-3** Дотоод аудитыг эрсдэлд суурилан үр нөлөөтэй, мэргэжлийн стандартын дагуу гүйцэтгэх | **Арга хэмжээ-1** Дотоод аудитад хамрагдсан байгууллагуудын эрсдэлийг үнэлэх, нэгтгэж мэдээллийн санд оруулах | Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо | 2023 онд 22 байгууллага | 2024 оны жилийн байдлаар байдлаар 32 удаагийн дотоод аудитад эрсдэлийн үнэлгээ хийж, ажиллалаа.<br><br>**Үнэлгээгээр:** БАГА эрсдэлтэй-19 байгууллага, ДУНД эрсдэлтэй 11 байгууллага, ИХ эрсдэлтэй 1 байгууллага дүгнэгдсэн. Дотоод аудитын эрсдэлийн үнэлгээг нэгтгэн “Эрсдэлийн мэдээллийн сан”-г баяжуулж ажиллалаа. | 100% |
| 6 | | **Арга хэмжээ-2** | Дотоод аудитад | 2023 онд 22 байгууллага | | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Улс, орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит байгууллага тусгай сан, тусгай шилжүүлэг, төсөл хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлд дотоод аудит гүйцэтгэх | хамрагдах байгууллагын тоо | | 2024 онд 32 байгууллагын 2023, 2024 оны санхүү, үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгэн үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж хүргүүлж ажиллалаа. Дүгнэлтээр:<br>- 9 байгууллага “Хангалттай”<br>- 12 байгууллага “Сайжруулах шаардлагатай”<br>- 1 байгууллаган “Хангалттай бус” гэж дүгнэгдлээ. | |
| 7 | **Зорилт-4** Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг хангуулах | **Арга хэмжээ-1** Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах байгууллагын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд улирал бүр дотоод аудит гүйцэтгэх | Хэрэгжилтийн хувь | 2023 онд 98 хувь | Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2023 оны IV улирал, 2024 оны I, II, III улирлын байдлаар 4 удаагийн дотоод аудитыг аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд гүйцэтгэн байгууллага бүрт дотоод аудитын тайланг хүргүүлж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Дотоод аудитын дүнг улирал бүрээр харуулбал: Үүнд:<br><br>**2023 оны IV улиралд:**<br>Нэгдсэн дүн-98%<br>Цаг хугацаандаа мэдээлсэн байдал-98.2%<br>Иж бүрэн мэдээлсэн байдал-99.4% байна.<br><br>100% үнэлэгдсэн 7 байгууллага<br>90-99% үнэлэгдсэн 69 байгууллага<br>80-89% үнэлэгдсэн 6 байгууллага<br><br>**2024 оны I улиралд:**<br>Нэгдсэн дүн-97%<br>Цаг хугацаандаа мэдээлсэн байдал-99.4%<br>Иж бүрэн мэдээлсэн байдал-97.2%<br><br>100% үнэлэгдсэн 33 байгууллага<br>90-99% үнэлэгдсэн 46 байгууллага | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | | | | | 80-89% үнэлэгдсэн 5 байгууллага<br><br>**2024 оны II улиралд:**<br>Нэгдсэн дүн-97%<br>Цаг хугацаандаа мэдээлсэн байдал-98.9%<br>Иж бүрэн мэдээлсэн байдал-97.7%<br><br>100% үнэлэгдсэн 35 байгууллага<br>90-99% үнэлэгдсэн 42 байгууллага<br>80-89% үнэлэгдсэн 7 байгууллага<br><br>**2024 оны III улиралд:**<br>Нэгдсэн дүн-98%<br>Цаг хугацаандаа мэдээлсэн байдал-99.6%<br>Иж бүрэн мэдээлсэн байдал-99.2%<br><br>100% үнэлэгдсэн 52 байгууллага<br>90-99% үнэлэгдсэн 29 байгууллага<br>80-89% үнэлэгдсэн 3 байгууллага<br><br>Улирал бүрийн дотоод аудитын нэгдсэн тайланг албан бичгээр Сангийн яам, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэн ажилласан.<br>Мөн Баян-Өндөр сумын Засаг дарга, Жаргалант сумын Засаг дарга, аймгийн ОНӨГазар аймгийн БШУГазар, СУГазарт тус бүр холбогдох байгууллагуудын нэгдсэн тайланг албан бичгээр хүргүүлэн ажилласан байна.<br>Дотоод аудитаар 80 хувиас доош үнэлэгдсэн 5 байгууллагад мэдээлэл байршуулалтыг сайжруулах албан бичиг хүргүүлсэн байна. | |
| 8 | | **Арга хэмжээ-2**<br>Мэргэжилтэй албан хаагчид болон улс, орон нутгийн | Сургалтад хамрагдах байгууллага, албан | 2023 онд давхардсан тоогоор 206 байгууллагын | Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, ажил, үйлчилгээ гүйцэтгэгч байгууллагын албан хаагчдыг сургалтаар, иргэд олон нийтийг мэдээ мэдээллээр хангах | хаагчийн тоо | 268 албан хаагч | нийтлэг стандартыг тогтоох журам"-ын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор албаны 2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 4 удаагийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж, давхардсан тоогоор 172 байгууллагын 288 мэдээлэл оруулагч нар болон албаны холбогдох албан хаагчид сургалт, мэдээлэл өгч, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Үүнд:<br><br>1. Шилэн дансны нэгдсэн системд мэдээлэл байршуулах эрх бүхий албан хаагчдад "*2023 он, 2024 оны I улирлын дотоод аудитын нэгдсэн дүн, нийтлэг алдаа, зөрчил, цахим системд мэдээлэл байршуулахад анхаарах зарим асуудал*" сэдвээр ээлжит сургалтыг цахимаар зохион байгууллаа. Сургалтад 50 байгууллагын 50 мэдээлэл оруулагч хамрагдлаа.<br>2. Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлэл оруулагч нарын мэдээлэл байршуулалтыг сайжруулах арга зүй" сэдэвт сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр шилэн дансны нэгдсэн цахим системд 2-оос дээш мэдээлэл оруулагчтай байгууллагуудын мэдээлэл оруулагч, нягтлан бодогч нарт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 9 байгууллагын 29 албан хаагч хамрагдлаа. Сургалтад хамрагдсан албан хаагчдад "Шилэн дансны нэгдсэн цахим систем"-ийн гарын авлага, календарчилсан төлөвлөгөө, сургалтын хэрэглэгдэхүүнийг тараан ажиллалаа.<br>3. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаас өгсөн зөвлөмжийн хүрээнд "Шилэн дансны цахим системд хандалт хийх арга | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зүй” сэдэвт сургалтыг Орхон аймгийн Баян-өндөр сум, Жаргалант сумуудын 29 багийн ажлын алба, Иргэдийн нийтийн хурал, иргэдийн төлөөллийг хамруулан 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Баян-Өндөр сумын ажлын алба, иргэдийг **“Залуучуудын ордон”**-д, Жаргалант сумын ажлын алба болон иргэдийг **“Жаргалант сумын ИНХ-ын танхим”-д** зохион байгуулсан. сургалтад Орхон аймгийн 29 багийн ажлын албаны албан хаагч 125, Иргэдийн нийтийн хурал, иргэдийн төлөөлөл 88, нийт 213 иргэн, албан хаагч хамрагдсан байна.<br>4. Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны нэгдсэн системд мэдээлэл байршуулах эрх бүхий албан хаагчдад *2023 оны нэгдсэн дүн, 2024 оны I, II, III улирлын дотоод аудитын нэгдсэн дүн, нийтлэг алдаа, зөрчил, цахим системд мэдээлэл байршуулахад анхаарах зарим асуудал*” сэдвээр ээлжит сургалтыг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр танхимаар зохион байгууллаа. Сургалтад 71 байгууллагын 71 мэдээлэл оруулагч хамрагдсан.<br>5. Мөн Оюу, 18 дугаар цэцэрлэг, Уран эгшиг, 16 дугаар сургууль, Жаргалант сумын Эрүүл мэндийн төв, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж, Хүүхэлдэйн театр, Соёл урлагийн газар, Нийтийн номын төв, Орхон аймгийн Эрүүл мэндийн газар зэрэг 10 байгууллагын нягтлан бодогчдод ажлын байранд ганцаарчилсан зөвлөгөө өгч, 45 байгууллагын нягтлан бодогчдод утсаар зөвлөгөө, мэдээлэл өгч, арга зүйгээр хангаж ажилласан байна. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 9 | | **Арга хэмжээ-3**<br>“Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэргэжилтэй албан хаагч, Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, ажил, үйлчилгээ гүйцэтгэгч байгууллагын албан хаагч, иргэдийг мэдээллээр хангах | Хэвлэл мэдээллийн байгууллага, мэдээллийн самбар, цахим сайт | 2023 онд 4 удаа | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, сурталчлах зорилгоор дараах арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажилладаг. Үүнд:<br>1. Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, мэдээлэл оруулагч нарт “*Шилэн дансны нэгдсэн цахим хуудас-СХДАА*”, “*Орхон Төрийн сан*” зэрэг цахим хуудсаар дамжуулан Шилэн дансны цахим системийн шинэчлэл, бүртгэл үүсгэх, мэдээлэл байршуулалттай холбоотой зөвлөгөө, мэдээллийг сар бүр хүргэж ажиллаж байна.<br>2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын дүн, холбогдох мэдээллийг “Тусгал” телевизэд 4 удаа ярилцлага өгч иргэд олон нийтийг мэдээллээр ханган ажиллалаа. Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсээс Номин телевизтэй хамтран зохион байгуулдаг Хуулийн цаг нэвтрүүлэгт 2 удаа мэдээлэл өгч, иргэд, олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан.<br>3. www.Sankhuu.audit.or.gov.mn албаны сайт, мэдээллийн самбарт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын дүнг, сургалт, мэдээ мэдээллийг тогтмол байршуулж байна.<br>4. Аймгийн Засаг даргын 2023 оны А/845 дугаар захирамжаар шинээр байгуулагдсан “Худалдан авах ажиллагааны газар”, “Баян-Өндөр” цэцэрлэг зэрэг 2 байгууллагад 2024 оны 02 дугаар сард Шилэн дансны нэгдсэн цахим системд цэс үүсгэж, бүртгэсэн. | 100% |
| **Биелэлтийн хувь** | | | | | | **100%** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| ***Ерөнхий чиг үүрэг-2:*** *Хариуцлагын тогтолцоог төлөвшүүлж, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх* | | | | | | |
| ***Үндсэн чиг үүрэг-2:*** *Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудад санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэх* | | | | | | |
| 10 | **Зорилт-1** Улс, орон нутгийн төсвийн хэмнэлттэй, зүй зохистой зарцуулагдаж буй эсэхэд дүгнэлт өгөх, хариуцлагын тогтолцоог сайжруулах, эрсдэлийг бууруулах | **Арга хэмжээ-1** Санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын эрсдэлийг үнэлэх, нэгтгэж мэдээллийн санд оруулах | Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо | 2023 онд 27 байгууллага | 2024 оны дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 28 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэн албаны даргын А/23 дугаар тушаалаар баталсан “Эрсдэлийн менежментийн журам”-ын дагуу эрсдэлийг үнэлж, нэгтгэлээ.<br>Санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан 28 байгууллагын эрсдэлийг үнэлж, БАГА эрсдэлтэй-12 байгууллага, ДУНД эрсдэлтэй-14 байгууллага, ИХ эрсдэлтэй-2 тус тус үнэлэгдсэн байна.<br>28 байгууллагын эрсдэлийн үнэлгээг нэгтгэн албаны “Эрсдэлийн мэдээллийн сан”-д орууллаа. | 100% |
| 11 | | **Арга хэмжээ-2** Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах төсвийн байгууллага, тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон иргэний гомдлын дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт, шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрагдах байгууллагын тоо | 2023 онд 27 байгууллага | 2024 онд 28 байгууллагын 2023 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалтыг аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд гүйцэтгэн дүгнэлт, зөвлөмж өгч, биелэлтийн тайланг албан бичгээр ирүүлж ажилласан байна. | 100% |
| 12 | | **Арга хэмжээ-3** Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар гүйцэтгэсэн хяналт шалгалтын тоон тайлан мэдээг гаргах | Жилд 4 удаа | 2023 онд тоон тайлангийн нэгтгэл 4 удаа | 2024 онд улирал тутамд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын тоон мэдээг 4 удаа нэгтгэн дүгнэлээ.<br>2024 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөт дотоод аудит болон санхүүгийн хяналт шалгалтаар Улсын байцаагчийн 28 актаар 31,001.4 мянган | 100% |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>төгрөгийн нөхөн төлбөр тогтоож 27,267.2 мянган төгрөгийн 22 нөхөн төлбөрийн актын төлбөрийг барагдуулж биелэлт 88 хувьтай, 3,734.2 мянган төгрөгийн актын үлдэгдэлтэй байна. Өмнөх оны нөхөн төлбөрийн актын үлдэгдэл бүрэн барагдаж, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 100 хувь хангагдсан байна.<br>Мөн 2,302,736.2 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн 34 албан шаардлага хүргүүлснээс жилийн эцсийн байдлаар 24 албан шаардлагын 2,108,404.4 мянган төгрөгийн биелэлт хангагдаж 92 хувьтай, бусад зөрчилд нийт 220 зөвлөмж өгөгдсөн байна.
<table>
<tr><th>Зөрчил арга хэмжээ</th><th>Тогтоосон</th><th>Арилсан</th><th>Биелэлт %, үлдэгдэл</th></tr>
<tr><td>Нийт зөрчлийн тоо</td><td>225</td><td>159</td><td>84%</td></tr>
<tr><td>Актын тоо</td><td>28</td><td>22</td><td>79%</td></tr>
<tr><td>Актын дүн</td><td>31,001.4</td><td>27,267.2</td><td>3,734.2</td></tr>
<tr><td>Албан шаардлагын тоо</td><td>34</td><td>24</td><td>92%</td></tr>
<tr><td>Албан шаардлагын дүн</td><td>2,302,736.2</td><td>2,108,404.4</td><td>194,331.8</td></tr>
</table>
</td><td></td></tr>
<tr><td colspan="6">Биелэлтийн хувь</td><td></td></tr>
<tr><td colspan="6">Ерөнхий чиг үүрэг-3: Монгол Улсын төрөөс баримтлах хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хანган ажиллах</td><td></td></tr>
<tr><td colspan="7">Үндсэн чиг үүрэг-3: Албаны хэмжээний бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах</td></tr>
<tr><td>13</td><td></td><td>Арга хэмжээ-1 Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн</td><td>Хэрэгжилтийн хувь</td><td>2023 онд 98 хувь</td><td>Байгууллагын мэдээллийн санд бүртгэлтэй 9 тогтоол, шийдвэрийг хяналтад авч, биелэлтийг хэрэгжүүлэн ажилласан.</td><td>99%</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **Зорилт-1** Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хантан ажиллах | газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хантан ажиллах | | | | |
| 14 | | **Арга хэмжээ-2** Аймгийн ИТХ-ын болон тэргүүлэгчдийн хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хантан ажиллах | Хэрэгжилтийн хувь | 2023 онд 94 хувь | Албаны мэдээллийн санд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын **3** тогтоолыг хяналтад авч хэрэгжилтийг хангаж ажилласан. | 100% |
| 15 | | **Арга хэмжээ-3** "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан холбогдох заалтыг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хантан ажиллах | Хэрэгжилтийн хувь | 2023 онд 90 хувь | **Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:** **1. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах зохион байгуулалтын арга хэмжээ авах:** Албан хаагчдын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхдээ хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээг 14 үзүүлэлтээр дүгнэсэн. Жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор хуулийн хугацаанд дүгнэж, үр дүнгийн урамшууллыг олгоно. Монгол улсын ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.4, 2.5 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | А/14 тоот тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г байгуулсан. Хорооноос 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2 зорилт, 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ёс зүйн дэд хорооноос болон бусад байгууллагаас зохион байгуулсан 11 удаагийн дотоод сургалтад давхардсан тоогоор 53 албан хаагч 23 цаг 40 минутын хүн/цаг, ёс зүйн хорооны дарга, гишүүд 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 9 албан хаагч хамрагдаж 1 цаг 40 минутын хүн/цаг зарцуулсан. Үүнд:<br>- Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” сэдэвт сургалтад бүх албан хаагчид хамрагдлаа.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг албаны https://sankhuu.orkhon.gov.mn/ цахим сайт, албаны дундын групп-т тус тус байршуулж, албан хаагчдад танилцуулж ажиллалаа.<br>- Төрийн албаны зөвлөл, Орхон аймаг дахь салбар зөвлөлтэй хамтарсан 2 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад албаны дарга, ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, хяналт- шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нар танхимаар, бусад албан хаагчид цахимаар хамрагдсан.<br>- Албанд шинээр томилогдсон 3 албан хаагчдад томилогдсон тухай бүр Төрийн албаны ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дүрэм, бусад холбогдох албаны дүрэм, журмыг танилцуулж, цаашид төрийн албаны ёс зүйн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэм хэмжээг мөрдөж ажиллах тухай мэдээ, мэдээллээр хангаж зөвлөгөө өгч ажилласан.<br>- Улаанбаатар хотын “Ёс зүйн академи”-аас зохион байгуулсан “Ажлын байрны ёс зүй, ажлын ёс зүй, хувь хүний ёс суртахуун болон ёс зүйн тухай хууль тогтоомж” сэдэвт сургалтад албаны ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд хамрагдсан.<br>2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөр төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэл ирээгүй болно.<br>**2. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг тухайн байгууллагуудын жил бүрийн төлөвлөгөөнд тусган шийдвэрүүлэх ажлыг зохион байгуулах:**<br>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2024 онд 3 зорилт, 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. | |
| 16 | | **Арга хэмжээ-4**<br>Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Хэрэгжилтийн хувь | 2023 онд 100 хувь | 2024 онд жилийн байдлаар Аймгийн Засаг даргын **12** захирамжийн биелэлтийг хангаж ажиллалаа. Үүнд:<br>1. **“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай**” (**2024.01.18-Б/06)**<br>- Тэргүүн зэргийн ахлах түшмэл–1, Тэргүүн зэргийн дэс түшмэл-2, Дэд зэргийн дэс түшмэл-1 нийт 4 албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс шинэчлэн тогтоож ажиллалаа.<br>2. **“Цалин хөлсний хэмжээ шинэчлэн тогтоох тухай”, (2024.01.25-А/60)**<br>- Албаны даргын цалин хөлс, зэрэг дэвийн нэмэгдлийг шинэчлэн тогтоосныг мөрдөн олгож байна. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **3. “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай”, (2024.03.18-А/178)**<br>- Албаны 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн Хяналт шинжилгээ үнэлгээнд хамрагдан өгсөн зөвлөмжийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан албаны даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр И-оффис системээр аймгийн Засаг даргын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж ажилласан.<br>**4. “Цалин хөлсний хэмжээ шинэчлэн батлах тухай”, (2024.04.08-А/246)**<br>- Аймгийн ИТХ-н 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Ээлжит XVII хуралдааны 17/04 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын А/246 тоот захирамжаар албаны даргын цалин хөлсийг шинэчлэн тогтоож, А/60 тоот захирамжийг хүчингүй болгосон. 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн А/246 дугаар захирамжийн биелэлтийг ханган ажилласан.<br>**5. “Албаны бүтэц, орон тоог батлах тухай”, (2024.05.01-А/315)**<br>Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолоор ТҮ-ний албан хаагчдын ангилалыг шинэчлэн баталсныг үндэслэн өөрчлөлт оруулав.<br>Үүнд:<br>1. Албаны дарга, Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч-1, ТЗ-4<br>2. Ахлах мэргэжилтэн, Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч /улсын ахлах байцаагч/-1, ТЗ-7<br>3. Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч-2, ТЗ-6<br>4. Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч-1, ТЗ-7 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 5. Дотоод аудитор-2, ТЗ-7<br>6. Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн-1, ТЗ-9<br>7. Нягтлан бодогч-1, ТҮМ-6<br>8. Архив, бичиг хэргийн эрхлэгч-1, ТҮМ-3<br><br>Нийт ТЗ-8, ТҮМ-2 10 орон тоогоор батлагдсан орон тоог мөрдөн ажиллаж байна.<br>**6. “Урамшуулал олгох тухай”, (2024.05.08-А/337)**<br>- Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/337 тоот “Урамшуулал олгох тухай” захирамжийн дагуу“ урамшууллын тооцоог хийж, 6 албан хаагчдад 42 сая.төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон.<br><br>**7. “Мөнгөн урамшуулал олгох тухай”, (2024.06.20, А/460)**<br>- Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/460 дугаар “Мөнгөн урамшуулал олгох тухай” захирамжийн дагуу“ албаны даргад үр дүнгийн урамшууллыг олгосон.<br>**8. “Ажлын өдөр шилжүүлэх тухай” (2024.07.23, А/530)**<br>- Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/530 дугаар “Ажлын өдөр шилжүүлэх тухай” захирамжийн дагуу 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн ажлыг 2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн Бямба гарагт, 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн ажлыг 2024 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн Бямба гарагт шилжүүлж ажилласан.<br>**9. “Хариуцлагатай эргүүл, жижүүрийг ажиллуулах тухай”, (2024.07.30, А/561)**<br>- Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/561 дугаар тоот захирамжийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дагуу Албаны хэмжээнд хариуцлагатай эргүүл, жижүүрийг хуваарь гарган 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 03-ны хооронд хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэх 2 албан хаагчийг томилсон.<br>- 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 03-ны хооронд хариуцлагатай эргүүл, жижүүрээр ажиллах хугацаанд Захиргааны III байр болон албаны өрөөнүүдийн ус, тог цахилгааны аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан.<br>- Эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаанд Захиргааны III байранд гарсан зөрчилгүй тайван байсан.<br><br>**10. “Бүх нийтээр мод тарих намрын ажил зохион байгуулах тухай”, (2024.09.26, А/666)**<br>- Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/666 дугаар тоот захирамжийн дагуу бүх нийтээр мод тарих намрын ажлын төлөвлөгөөний дагуу 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Тарлан толгойн энгэрт байгууллагын бүх албан хаагчид 50 голтбор суулгасан.<br>**11. “Шагнаж урамшуулах тухай” (2024.10.28, А/767)**<br>- Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/767 дугаар захирамжийн дагуу захирамжийн дагуу“ албаны даргад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгосон.<br>**12. “Хариуцлагатай эргүүл жижүүрийг ажиллуулах тухай”, (2024.12.23, А/957)**<br>- Албаны даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/38 дугаартай тушаалаар хариуцлагатай жижүүрээр ажиллах албан хаагчдыг томилон, | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хуваарийн дагуу албан хаагчид хариуцлагатай эргүүл, жижүүрийн үүргийг гүйцэтгэж ажилласан. | |
| 17 | | **Арга хэмжээ-5** Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах | Хэрэгжилтийн хувь | 2023 онд 100 хувь | Аймгийн Засаг даргын шуурхай хуралдаанаас ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:<br>1. **2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Аймгийн Засаг даргын шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу:**<br>- Албаны даргын 2024 оны А/04 дүгээр "Хөрөнгө зарцуулах тухай" тушаалыг үндэслэн албаны 4 өндөр настанд Сар шинийн баяраар 200.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон.<br>- Мөн албаны даргын тушаалаар Сар шинийн баярын өдрүүдээр ажиллах “Хариуцлагатай жижүүрийн хуваарь” гарган мөрдөж ажилласан.<br>2. **2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн Аймгийн Засаг даргын шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу:**<br>- Аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулж буй "Малчдад туслая аян"-ы хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны албан хаагчид өөрсдийн бэлтгэсэн 14 ширхэг нэмнээ, элгэвч мөн 10 шуудай хивгийг /малын тэжээл/ Онцгой байдлын газрын нөөцийн 119 дүгээр ангийн няравт хүлээлгэн өгсөн.<br>3. **2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн Аймгийн Засаг даргын шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу:**<br>- Үүрэг даалгаврын хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны албан хаагчид Захиргааны III байрны гадна талбайн хуваарилагдсан хэсгийн хогийг, мөн ИХ ХОТЫН ЦЭВЭРЛЭГЭЭ-нд нэгдэн Төрийн захиргааны 3 дугаар байрны Тракторын хөшөө орчимд их цэвэрлэгээ хийлээ. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 18 | | **Арга хэмжээ-6**<br>Авлигын эсрэг хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх | Хэрэгжилтийн хувь | 2023 онд 96 хувь | Албаны даргын 2024.02.01-ний өдрийн Б/04 дугаартай тушаалаар албаны эрх бүхий албан тушаалтанг шинэчлэн томилсон.<br>Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Орхон аймгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган биелэлтийн тайланг хагас, бүтэн жилээр аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэст 2024.06.25-ны өдөр, 2024.12.05-ны өдөр албан бичгүүдээр хүргүүлж ажилласан.<br>2024 онд төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:<br>1. 2024 оны онд аймгийн Засаг даргын баталсан бүтэц орон тоогоор ажиллалаа.<br>2. 2024 онд Авлигын эсрэг хуульд заасан хугацаанд Төрийн захиргааны 6 албан хаагчаас ХАСУМ, ХАСХОМ-ийг хүлээн авч, баталгааны хуудсаар баталгаажуулан, холбогдох бүртгэлийг хөтлөн баримтжуулж, аймгийн ЭБАТ-д нэгтгүүлэн ажилласан.<br>3. 2024 онд албанд Төрийн захиргааны 3 албан хаагчийн сул орон тоо гарсан тухай бүр Төрийн албаны Орхон аймаг дахь салбар зөвлөлд албан хүсэлт, холбогдох материалыг хүргүүлж, ил тод байдлыг ханган ажилладаг. Авлигатай тэмцэх газрын 05/16034, 05/17818 ирүүлсэн бичгийг үндэслэн албаны даргын тушаалаар “Шилжих, сэлгэн ажиллах журмын хүрээнд 2 албан хаагчийг үндсэн орон тоонд, нөөцөд бүртгэлтэй 1 иргэнийг түр орон тоонд тус тус томилсон байна. Мөн Төрийн үйлчилгээний 1 албан хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж, 1 иргэнийг | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сонгон шалгаруулж, Архив, бичиг хэргийн эрхлэгчийн орон тоонд албаны даргын Б/09 тушаалаар томилсон байна.<br>4. 2024 онд өөр албан тушаалд дэвшин томилогдсон 1 албан хаагч, шинээр томилогдсон 2 албан хаагч, хүүхэд асрах чөлөө дуусгавар болж, ажилдаа эргэн орсон 1 албан хаагчаас хуулийн хугацаанд 2023 оны ХАСУМ, ХАСХОМ-ийг тухай бүр хүлээн авч, баталгааны хуудсаар баталгаажуулан, холбогдох бүртгэлийг хөтлөн баримтжуулж, аймгийн ЭБАТ-д нэгтгүүлэн ажилласан.<br>5. 2024 онд хүний нөөцийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, албан хаагчдын мэдээллийг өөрчлөлт орох бүрт Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд болон хувийн хэргийн хавтаст баяжилтыг тухай бүр шинэчлэн ажиллалаа.<br>6. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Хүний нөөцийн аудитад хамрагдаж, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>7. Албаны www.sanhuu.orkhon.gov.mn сайт, Авлига-Ил тод байдлын мэдээллийн самбарт 12 удаа холбогдох мэдээ, мэдээллийг шинэчлэн байршуулж, өөрчлөлт шинэчлэлт хийх албан хаагчаар Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтнийг даргын тушаалаар томилон, шуурхай хуралдаанаар үүрэгжүүлэн ажиллуулж, иргэд олон нийтийн мэдээлэл авах эрхийг ханган ажиллаж байна.<br>8. Ажлын байр, албан өрөөнүүдэд Авлигыг мэдээлэх утас, Авлигаас ангид байхыг сануулсан зурагт хуудсыг 10 албан хаагчдын компьютер бүрт байршуулсан. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 9. 2024 онд иргэн, байгууллага, албан хаагчдаас ирүүлсэн 48 удаагийн өргөдөл хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэн утсаар болон амаар хариу өгч ажилласан.<br>10. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд албаны даргын А/30 дугаартай тушаалаар томилогдсон Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй томилж, дэд хорооноос 2 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган хагас, бүтэн жилээр биелэлтийн тайланг Төрийн албаны Орхон аймаг дахь салбар зөвлөлд тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан байна.<br>11. Албаны Эрх бүхий албан тушаалтны чиг үүргийг шинээр томилогдсон Ахлах мэргэжилтэнд албаны даргын тушаалаар шилжүүлсэн тул аймгийн Эрх бүхий албан тушаалтан Л.Түмэннастад мэдэгдэж, баталгааны маягтыг гарган зөвлөгөө мэдээлэл авч ажилласан.<br>12. 2024 онд албаны даргын тушаалаар Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг 2 хүний бүрэлдэхүүнтэй томилж, жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган, хагас, бүтэн жилээр биелэлтийн тайланг албаны дарга, холбогдох албан хаагчдад танилцуулж, дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан байна.<br>13. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны ажлын төлөвлөгөө, Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001-2016 Олон улсын стандартын хэрэгжилтийг хангах, байнгын сайжруулалт хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган, биелэлтийн тайланг хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллаж байна. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 14. Мөн Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001-2016 Олон улсын стандартын хэрэгжилтэд хийсэн магадлан аудитад амжилттай хамрагдаж, үл тохиролгүй дүгнэгдсэн байна.<br>15. 2024 оны 01 дүгээр сард Аймгийн Засаг дарга буюу Аймгийн Дотоод аудитын хорооны даргаар 2024 оны “Дотоод аудит-санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө”-г 60 байгууллагад хяналт хэрэгжүүлэхээр батлуулан, хэрэгжилтийг 100 % ханган ажиллаж байна.<br>16. Дээд шатны байгууллагын нэгдсэн удирдамж, аймгийн Засаг даргаас өгсөн чиглэл, иргэний гомдлын дагуу нийт 19 байгууллагад аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна.<br>17. 2024 онд дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдсан 79 байгууллагын удирдлага, холбогдох албан хаагчдад дотоод аудитын тайлан, хяналт шалгалтын танилцуулга болон шалгалтаар илэрсэн зөрчилд ногдуулсан нөхөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг танилцуулан, мэргэжил, арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа.<br>18. Дотоод аудит, хяналт шалгалт гүйцэтгэсэн Дотоод аудитор, СХШУ(А)Б нартай холбоотой ашиг сонирхлын зөрчил, санал гомдол ирээгүй байна.<br>19. 2024.06.03-ны өдөр Аймгийн Дотоод аудитын хорооны хурлыг зохион байгуулж, хурлаар албаны 2023 оны ажлын тайлан, 2024 оны дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөө, биелэлт, 2022-2024 онд шинээр батлагдсан эрх зүйн актуудын хүрээнд шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг тусган “Санхүүгийн хяналт дотоод | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аудитын албаны дүрэм", "Санхүүгийн хяналт шалгалт хийх журам", "Дотоод аудит хийх журам"-ын төслийг хэлэлцүүлэн батлуулж, ажилласан.<br>20. Авлигатай тэмцэх газраас ирсэн бичгийн үндэслэн холбогдох мэдээ, тайлан, судалгаа, зөрчлийн талаарх мэдээллийг тухай бүр хүргүүлэн ажилладаг.<br>21. 2024 оны 03 дугаар сард Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн бичгийг үндэслэн Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2016 Олон улсын стандартыг нэвтрүүлсэн тухай мэдээ, тайланг бэлтгэн албан бичгээр хүргүүлж ажилласан.<br>22. 2024 онд Авлигын эсрэг хууль, Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, бусад холбогдох эрх зүйн актын хүрээнд албаны ЭБАТ, албан хаагчид дээд шатны байгууллагаас болон албан хаагчид нийт 5 удаагийн сургалтад хамрагдсан байна.<br>- "Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Орхон аймгийн хэмжээнд Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт" сэдэвт сургалтыг аймгийн ЭБАТ-аас авч, албан хаагчдыг бүрэн хамрууллаа.<br>- Албаны ЭБАТ Дотоод аудитор-СХШУАБ О.Болормаа 2024 оны 01 дүгээр сард ХАСУМ, ХАСХОМ мэдээлэх чиг үүрэг бүхий 7 албан хаагчид дотоод сургалтыг зохион байгууллаа.<br>- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан ХАСУМ, ХАСХОМ-ийн маягтын өөрчлөлт, шинэчлэлтийг танилцуулах сургалтад албаны ЭБАТ хамрагдлаа.<br>23. Чанарын менежментийн багаас албан хаагчдад "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр-2023-2030"-ийг танилцуулах сургалтыг зохион байгууллаа. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 19 | | **Арга хэмжээ-7**<br>Албан хаагчдын мэдэгдэл тайлбар, ХАСУМ болон ХАСХОМ хуулийн хугацаанд гаргаж мэдүүлэх | ХАСУМ болон ХАСХОМ, мэдэгдэл тайлбар мэдүүлэгч албан хаагчийн тоо | 2023 онд ХАСУМ мэдүүлэгч-2, ХАСХОМ мэдүүлэгч-7, Мэдэгдэл тайлбар-1 | 2024 онд Төрийн захиргааны 8 албан хаагчаас ХАСХОМ-ийг төрийн захиргааны 7 албан хаагч мэдүүлсэн байна.<br>Албаны дарга Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст харьяалагдаж, ТЗ-9 ангилалд ажилладаг Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн ХАСХОМ мэдүүлэх бүртгэлд хамаардаггүй болно. | 100% |
| 20 | | **Арга хэмжээ-8**<br>Төсөв санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд НББОУС мөрдөж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах | Хуулийн хугацаа | 2023 онд Санхүүгийн тайланг 2 удаа, төсвийн гүйцэтгэлийн мэдээг-12 удаа тайлагнасан. | Албаны төсөв санхүү, Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд НББОУС мөрдөн, дараах тайлан мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан. Үүнд:<br>1. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гарган цахимаар илгээж, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэн, хянуулж, хуулийн хугацаанд баталгаажуулж ажилласан.<br>2. Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас 2023 оны жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн баримтад аудит хийж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган биелэлтийн тайланг албан бичгээр хүргүүлж ажилласан.<br>3. 2024 онд 12 удаагийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 12 удаагийн нийгийн даатгалын тайлан, 2 удаагийн татварын тайланг бэлтгэн аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.<br>4. 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг 2024.07.20-ны өдөр цахимаар илгээж, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэн, хянуулж, хуулийн хугацаанд баталгаажуулж ажилласан.<br>5. 2025 оны төсвийн төсөөллийг боловсруулан аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлтэст тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан.<br>6. Жилийн эцсийн санхүүгийн тайлан, мэдээ хүргүүлэх хуулийн хугацаа болоогүй. | |
| **Биелэлтийн хувь:** | | | | | | **100%** |
| ***Ерөнхий чиг үүрэг-4:*** *Чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, ил тод төрийн албыг төлөвшүүлэх* | | | | | | |
| ***Үндсэн чиг үүрэг-4:*** *Өсөн дэвжих эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцийг бүрдүүлэх* | | | | | | |
| 21 | **Зорилт-1**<br>Өсөн дэвжих эрмэлзэлтэй, чадахуйн зарчимд суурилсан, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх | **Арга хэмжээ-1**<br>Албан хаагчдыг мэргэшүүлэх болон бусад сургалтад хамруулж, мэдлэг чадвар чадамжийг дээшлүүлэх | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | 2023 онд 56 удаагийн сургалтад давхардсан тоогоор 115 албан хаагч | Албаны 2024 оны сургалтын төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган, албаны даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.<br><br>2024 онд 8 удаагийн гадагшаа чиглэсэн сургалт 1327 төрийн албан хаагч, хувийн хэвшил, аж ахуй нэгж байгууллагууд, иргэний төлөөлөл , дээд шатны байгууллагуудаас зохион байгуулсан болон ажлын байранд зохион байгуулсан 61 удаагийн сургалтад давхардсан тоогоор 274 албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн. | 100% |
| 22 | | **Арга хэмжээ-2**<br>Дотоод аудиторуудыг дотоод аудитын чиглэлээр сургаж, мэргэшүүлэх, дадлагажуулах, Санхүүгийн хяналт шалгалтын стандарт, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөх | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | 2023 онд 1 албан хаагч | Дотоод аудиторуудыг дотоод аудитын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад 2 албан хаагчийг хамруулсан. Үүнд:<br>1. ММНБИ-ээс зохион байгуулсан Мэргэшсэн дотоод аудитор бэлтгэх сургалтад 2024.05 сард Дотоод аудитор М.Энхтуяаг хамруулж, №1776 дугаартай гэрчилгээ авсан.<br>2. Албаны Нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилтэд дотоод аудит гүйцэтгэх эрх бүхий Дотоод аудитор бэлтгэх “Менежментийн тогтолцооны аудитын заавар” MNS.ISO.19011:2020 стандартын сургалтад 1 албан хаагчийг №МТСЛСТ 1292/24 дугаартай гэрчилгээ авсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3. 2024 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Монгол Улсын Дотоод аудиторуудын форум"-д албаны 4 албан хаагч оролцлоо. | |
| 23 | | **Арга хэмжээ-3**<br>Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх | Хэрэгжилтийн хувь | 2023 онд 92 хувь | Албаны даргын 2024 оны А/14, А/30 дугаартай тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:<br>- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг албаны https://sankhuu.orkhon.gov.mn/ цахим сайт, албаны дундын групп-т тус тус байршуулж, албан хаагчдад танилцуулж ажиллалаа.<br>- Шинээр томилогдсон 4 албан хаагчид “Төрийн албаны ёс зүйн тухай хууль”, Ёс зүйн дүрэм, журмыг танилцуулж, цаашид төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагаа дээшлүүлж ажиллах талаар зөвлөгөө өгсөн.<br>- 2024 онд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс гомдол ирээгүй болно.<br>- 2024 онд Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор дээд шатны байгууллагуудаас зохион байгуулсан 5 удаагийн сургалтад албаны дарга, хорооны гишүүд хамрагдсан. Үүнд:<br>  - “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” судэвт сургалт<br>  - "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт", "Төрийн албаны | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан"-ийн танилцуулга” сургалт<br>- “Ажлын байрны ёс зүй, ажлын ёс зүй, хувь хүний ёс суртахуун болон ёс зүйн тухай хууль тогтоомж” сэдэвт сургалт<br>- “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Захиргааны ерөнхий хуулийн агуулга, хэрэглээнд анхаарах асуудал”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хэрглээнд анхаарах асуудал” сэдэвт сургалт<br>- Ёс зүйн академаас Эрдэнэт хотод зохион байгуулсан “Байгууллагын ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт сургалт<br>- Албаны Ёс зүйн дэд хорооноос нийт албан хаагчдад 3 удаагийн дотоод сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:<br>- “Байгууллагын ёс зүй болон хувь хүний ёс зүй”<br>- “Ажлын байрны ёс зүй”<br>- “Өөртөө итгэх итгэл, сэтгэлийн хөдөлгөөнөө хянах”<br>Төлөвлөгөөний биелэлтийн тайланг хагас, бүтэн жилээр тогтоосон хугацаанд “Төрийн албаны Орхон аймаг дахь салбар зөвлөл”-д хүргүүлж ажиллалаа.<br>- | |
| 24 | **Зорилт-2**<br>Албан хаагчдын ажлын нөхцөлийг сайжруулж, тогтвортой ажиллах баталгааг хангах | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр батлагдсан “Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2023 онд 94 хувь | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг хангаан биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнан ажилллаcан. Үүнд:<br>1. Аймгийн Засаг даргын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн А/60 дугаар захирамжаар удирдах ажилтны цалин хөлсний хэмжээг шинэчлэн тогтоосон ба албаны даргын 2024.01.02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар албан хаагчдын | 95% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажил, албан тушаалын жагсаалт, үндсэн цалингийн сүлжээ, бусад нэмэгдлийн хэмжээг шинэчлэн баталж 2024 онд 10 орон тоог баталж ажилласан.<br>2. Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2024 оны 04 сарын 08-ны өдрийн А/246 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагын хавсралтад нэр тусгагдсан удирдах ажилтнуудын цалин хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож 2024 оны 04 сарын 01-ны өдрөөс мөрдөж эхэлсэн.<br>3. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 63/104 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-д заасны дагуу Нягтлан бодогч, Архив, бичиг хэргийн эрхлэгчид ур чадварын нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 20-25%-иар олгож байна.<br>4. Аймгийн Засаг даргын 2024.01.18-ны өдрийн Б/06 дугаар захирамжаар “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох” захирамжийн дагуу 4 албан хаагчид буюу 1 албан хаагчид тэргүүн зэрэг, ахлах түшмэл, 2 албан хаагчид тэргүүн зэрэг Дэс түшмэл, 1 албан хаагчид Дэд зэрэг Дэс түшмэлийн зэрэг дэвийг олгохоор шийдвэр гарч 2024.01.02-ны өдрөөс олгож эхэлсэн.<br>5. Албаны даргын 2022 оны 03 сарын 04-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хоолны зардалд 5000 төгрөгөөр олгож байсныг 2023 оны 10 сарын 27-ны өдрийн А/27 дугаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалаар Төрийн албаны ёс зүйн тухай хууль шинээр батлагдсан, албанд нэгдсэн менежментийн тогтолцоо хэрэгжиж байгаатай холбогдуулан Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлтийг 7.12-д заасан заалтаар оруулан хоол унааны мөнгийг 8500 төгрөг болгон олгохоор шийдвэрлэж, одоог хүртэл олгож байна.<br>6. 2024 онд албаны хэмжээнд 3 сул орон тоо, 1 түр орон тоонд дараах албан хаагчдыг авч ажиллуулж байна. Үүнд.<br>- 2024.03.29-ны өдрийн Б/09 дүгээр тушаалаар Архив-бичиг хэргийн эрхлэгчийн орон тоонд Б.Золжаргал<br>- 2024.07.09-ний өдрийн Б/16 дугаар тушаалаар ХШҮХМэргэжилтэн албан тушаалд П.Даваажаргал */Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 27.1.2 заалт, 44.3 заалт, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 3-р хавсралтыг тус тус үндэслэн/*<br>- 2024.09.09-ний өдрийн Б/19 дугаар тушаалаар Дотоод аудитор албан тушаалд П.Азхишиг */Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 27.1.2 заалт, 44.3 заалт, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 3-р хавсралтыг тус тус үндэслэн/*<br>- 2024.11. 08-ны өдрийн Б/27 дугаартай тушаалаар Дотоод аудитор Ч.Энхтуяагийн хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр “Дотоод аудитор”-ын орон тоонд Т.Онontуул | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 7. Албаны бичиг хэргийн зардал сард 300,0 мянган төсөв батлагдаж, жилийн эцсийн байдлаар 3.600,0 мянган төгрөгийн төсвийг зарцуулсан байна.<br>8. Албаны шатахууны зардал сард 300.0 мянган төсөвтэй ба жилийн эцсийн байдлаар 3,600.0 мянган төгрөгийн түлш шатах тослох материалыг анхан шатны баримтаар зарцуулсан.<br>9. Байгууллагын хэмжээнд байгууллагын соёлын зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх, байгууллагын соёлоо үнэлэх, цаашид эерэг хандлагыг түгээх чиглэлээр албан хаагчдыг сургалтад хамруулсан. Тус хөтөлбөрийн хэрэгжилтэд байгууллагаас 250.0 мянган төгрөгийн төсвийг зарцуулсан байна.<br>10. Албан хаагчдыг Баян-өндөр сумын зааланд 7 хоног бүрийн Даваа гаригийн 20 цагаас 2 цаг заал авч хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор арга хэмжээ авч ажиллаж байна.<br>11. Монгол улсын Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн нэгд заасан Эрүүл мэндийн бодлогын хүрээнд албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулахаар хөтөлбөрийн нэг арга хэмжээ болгон тусгасан. “Анхны оч” ӨЭМТ-д 2024 оны 10 сард албан хаагчдын эрүүл мэндэд анхаарч томуугийн вакцинд бүх албан хаагчдыг хамруулсан байна.<br>12. Албан хаагчдын ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор дараах тоног төхөөрөмж, тавилгыг худалдан авч албан хаагчид өгч ажилласан. Үүнд:<br>- 299.0 мянган төгрөгийн үнэ бүхий номын шүүгээ тавиурыг хүүхдийн өрөөнд | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - 2 дэлгэц, 1 өнгөт принтер, 1 сандлыг нийт 1,895.0 мянган төгрөг<br>13. Албаны хэмжээнд дараах албан хаагчдад тэтгэмж урамшууллыг олгож ажилласан байна. Үүнд:<br>- Цагаан сарын баярыг тохиолдуулан 4 ахмад настанд нийт 200.0 мянган төгрөгийн тэтгэмж<br>- Ахмад настан Т.Хандаагийн 2024.03.27-ны өдөр гаргасан өргөдлийн дагуу эмчилгээний зардалд 150.0 мянган төгрөгийг нэг удаагийн буцалтгүй тусламм<br>- СХШУБ-аар ажиллаж байсан С.Идэрмөнх хүнд өвчний улмаас нас барсан тул Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасны дагуу 60 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 87,120.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж<br>14. 2024 онд албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхижуулах зорилгоор дээд шатны байгууллагуудаас зохион байгуулсан 5 удаагийн хамруулж ажилласан. Үүнд:<br>- “Монголын үндэсний Дотоод аудиторуудын холбоо” ТББ-аас 2024.11.14-ны өдөр зохион байгуулагдсан “Монгол улсын Дотоод аудиторуудын форум”-д 4 албан хаагч<br>- Стандарт хэмжил зүйн газраас 2024.06 дугаар сард зохион байгуулсан “Менежментийн тогтолцооны аудитын заавар MNS ISO 19011:2020 стандарт”-ын сургалтад 1 албан хаагч<br>- Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт хэмжил зүйн газраас 2024.09.03-04-ний өдрүүдэд зохион байгуулсан “MNS ISO 9001:2016- Чанарын | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | менежментийн тогтолцоо, шаардлага" сэдэвт сургалтад 1 албан хаагч<br>- Удирдлагын академиас зохион байгуулдаг "Төрийн алба хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1 албан хаагч<br>- Удирдлагын академиас зохион байгуулдаг "Төрийн алба хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагч<br>15. Төлөвлөгөөний дагуу ажлын байранд 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Үүнд:<br>- 2024.05.14-ны өдөр "Гэр бүлийн үнэ цэн" сэдэвт сургалт<br>- Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран Монгол бичгийн нийт 23 цагийн сургалт<br>16. Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулсан. Үүнд:<br>- Архив бичиг хэргийн эрхлэгчийн өрөөний шалыг 400.00 мянган төгрөгөөр шинээр сольсон.<br>- Орон нутгийн өмчийн газар хүсэлт хүргүүлсэн дагуу 1 өрөөг албанд авч, 2,900.00 мянган төгрөгийн тохижилтийн ажлыг хийж, 2 албан хаагчийг тус өрөөнд шилжүүлж ажилласан. | |
| **Биелэлтийн хувь:** | | | | | | **100%** |
| ***Ерөнхий чиг үүрэг-4:*** *Чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, ил тод төрийн албыг төлөвшүүлэх* | | | | | | |
| ***Үндсэн чиг үүрэг-4:*** *Өсөн дэвжих эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцийг бүрдүүлэх* | | | | | | |
| 25 | **Зорилт-1** Байгууллагын мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах | **Арга хэмжээ-1** Байгууллагын ил тод байдал, үйл ажиллагааны түргэн шуурхай байдлыг хангаан ажиллах | Цахим сайт болон телевизийн мэдээлэлт ийн тоо | 2023 онд http://sankhuu.orkhon.gov.mn - 64, тусгал телевиз- 6 удаа мэдээ бэлтгэн нийтлүүлсэн. | 2024 онд албаны http://sankhuu.orkhon.gov.mn/ цахим хуудсанд **79** удаагийн мэдээ, мэдээллийг байршуулж ажилласан байна. Үүнд:<br>- Гадаад болон дотоод сургалттай холбоотой 28 мэдээлэл<br>- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны тайлан, мэдээг танилцуулсан 35 удаагийн мэдээлэл | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Нэгдсэн менежментийн тогтолцооны хүрээнд хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай холбоотой 16 мэдээлэл<br>Албаны пэйж хуудсанд 29 удаа мэдээ, мэдээллийг байршуулан ажилласан.<br>Ил тод байдлын самбарт холбогдох мэдээллүүдийг сар бүр буюу 6 удаа оруулж, 12, 1-5 дугаар сарын ажлын тайланг мөн 6 удаа байршуулж ажилласан.<br>Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хийсэн 2023 оны IV, 2024 оны I, II, III улирлын дотоод аудитын дүн, холбогдох мэдээллийг “Тусгал” телевизийн “Мэдээллийн хөтөлбөр”-т **4** удаа, “Хуулийн цаг” нэвтрүүлэгт **2** удаа ярилцлага өгсөн. | |
| 26 | | **Арга хэмжээ-2**<br>И-оффис системийн ашиглалтыг сайжруулах | Систем ашиглалтын тоо | 2023 онд ирсэн бичиг-224, явсан бичиг-153, албан хаагчдын ажлын төлөвлөгөө-426, өргөдөл гомдол-28, үүрэг даалгавар-2, дотоод мэдээ-1, зар мэдээлэл-3 | Байгууллагын И-Оффис системийн ашиглалт, бүртгэлийн тоо -**1106** байна. Үүнд:<br>- Явсан бичиг- 214,<br>- Ирсэн бичиг-216<br>- Өргөдөл гомдол-48<br>- Төлөвлөсөн бичиг-189<br>- Хурлын болон албаны даргаас өгсөн үүрэг даалгавар-60,<br>- Албан хаагчдын ажлын төлөвлөгөө-366,<br>- Дотоод зар, мэдээ, мэдээлэл байршуулсан тоо -13 | 100% |
| 27 | | **Арга хэмжээ-2**<br>Нэгдсэн менежментийн тогтолцооны ISO 9001:2015, ISO 37001:2016 | Стандартуудын шаардлагыг хангаж, аудитад хамрагдах | 2023 онд ISO 37001:2016 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. | Чанарын менементийн баг “Нэгдсэн менежментийн тогтолцооны ISO 9001:2015, ISO 37001:2016” стандартуудын байнгын сайжруулалтыг өдөр тутамдаа хийж, холбогдох тайлан, мэдээг гаргаж удирдлагад танилцуулж ,албан хаагчдын | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | стандартуудын байнгын сайжруулалтыг хийх | | | чадавхжуулах мэдлэг, мэдээллээр хангах ажлыг ажлыг тогтмол хийж хэвшсэн. | |
| **Биелэлтийн хувь** | | | | | | **100%** |
| **Нийт биелэлтийн хувь** | | | | | | **99.7%** |

ХЯНАСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА Д.САЙЗМАА

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ДОТООД АУДИТОР
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Л.БУЛГАНЦЭЦЭГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН П.ДАВААЖАРГАЛ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

**БҮЛЭГ ХОЁР:** МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөөний бүлэг | Шийдвэрийн агуулга | Хэрэгжилтийн тайлан | Биелэлт -ийн хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **2.1. ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХУУЛИАР ОЛГОСОН ЭРХ ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:** | | | | |
| 1 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг /Засгийн | 1.Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжигч төрийн байгууллага, | Аймгийн Засаг даргын орлогчийн баталсан удирдамжийн хүрээнд 2024 оны 1 дүгээр улирлын Шилэн дансны тухай хууль тогтоомжийн | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | газарт чиглэл өгөх тухай 2023.06.10 №88/ | түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх “шилэн данс”-ны тогтолцоонд шилжих; | хэрэгжилтэд Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагад **1** удаа дотоод аудитыг гүйцэтгэж, **2** зөрчлийг илрүүлсэн байна.<br>Дотоод аудитаар нийт 84 байгууллагаас 33-байгууллага 100%, 28-байгууллага 95-99%, 18 байгууллага 90-94%, 5 байгууллага 80-89%-тай дүгнэгдсэн.<br>2024 онд Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/845 дугаар захирамжаар Худалдан авах ажиллагааны газар байгууллагдсан. Мөн Баян-Өндөр цэцэрлэг 2024 оны 01 дүгээр сарын 29-ны өдрөөс үйл ажиллагаагаа эхлэн, Шилэн дансны нэгдсэн цахим системд 2024 оны 02 дугаар сард цэс үүссэн.<br>2024 оны 1 дүгээр улирлын байдлаар байгууллагуудын цаг хугацаандаа мэдээлэл байршуулсан байдал 99.4 хувь, иж бүрэн, үнэн зөв мэдээлсэн байдал 97.2 хувь, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн нэгдсэн дүн **96.6 хувьтай** дүгнэгдлээ. | |
| 2 | | 2.Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтад тавих иргэний хяналтын тогтолцоо хийгээд өнөөгийн эрх зүйн орчины талаар олон нийтэд сурталчилах, иргэдийн санал дүгнэлтийг хүлээн авсан эсэхийг эргэж мэдэгдэж байх тогтолцоог нэвтрүүлэх. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, сурталчлах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:<br>- Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлэл байршуулах эрх бүхий албан хаагчдад зориулсан 1 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, сургалтад 50 байгууллагын албан хаагч хамрагдлаа.<br>- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулдаг албан хаагчдыг Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, http://sankhuu.orkhon.gov.mn/, Orkhon turiin san цахим хуудас, төрийн байгууллагын нэгдсэн И-Оффис цахим системээр дамжуулан мэдээлэл байршуулах талаар цаг үеийн мэдээ, мэдээллээр хангаж ажилласан**.**<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээ, мэдээллийн талаар “Тусгал” телевизэд 2 удаагийн ярилцлага өгсөн. | 100% |
| 3 | Монгол Улсын Их Хурлын тогтоол /Чиглэл өгөх тухай 2014.05.01 №15/ | 1.Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, хэрэгжих боломжгүй төсөл сонгон шалгаруулсан болон | 2024 оны дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдах байгууллагуудын төлөвлөгөөнд Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан, Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сангийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийхээр төлөвлөсөн бөгөөд уг дотоод аудит сүүлийн хагас жилд хийгдэнэ. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | төслүүдийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаагүй албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох | | |
| 4 | | 2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэхээр гэрээ байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжүүдийн зөрчлийг хянан үзэж, тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах | Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Барилгын тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн журам, худалдан авах ажиллагаатай холбоотой журмуудын хэрэгжилтэд дотоод аудит гүйцэтгэсэн байна.<br>Дотоод аудитаар сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр "Болзошгүй аваарын зардал" гэж хуваарилан хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт болон орон нутгийн иргэдийн саналын эрэмбэд ороогүй дараах 12 ажлын гүйцэтгэлд нийт 209,009.4 мянган төгрөгөөр зарцуулсан, 2023 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд мэдээлбэл зохих мэдээллийг иж бүрэн мэдээлээгүй, Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах жилийн ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, удирдамжгүйгээр хяналт шалгалтыг зохион байгуулсан зэрэг 3 зөрчил илэрсэн тул тус сангийн 2023 оны үйл ажиллагааг ***САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ*** гэж дүгнэн, 1 албан шаардлага, ажмил сайжруулах 3 зөвлөмж хүргүүлсэн байна.<br>Цаашид аудитаар илэрсэн асуудалд анхаарч, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хэрэгжилтийг ханган ажиллах, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй ажлуудыг санхүүжүүлэхгүй байх, хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд иж бүрэн байршуулах, иргэд, олон нийтийг бодит, үнэн зөв мэдээллээр хангах, дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг удирдлага, албан хаагчдад танилцуулж хэвших, дотоод хяналт, хяналт шинжилгээ үнэлгээний чиг үүргийг тус тусад нь хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна. | 100% |
| 5 | Засгын газрын тогтоол "Дүрэм батлах тухай" | **"**Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” | | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 2019.01.23-ны өдрийн №33 | | Албаны ёс зүйн зөвлөлийн 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 2 зорилт 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган хэрэгжилтийг ханган ажиллаласан. Тухайлбал:<br>➢ Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/14 тоот тушаалаар байгууллагын Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан.<br>➢ "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх" сэдэвт сургалтыг албан хаагчдад зохион байгууллаа.<br>➢ Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг албаны https://sankhuu.orkhon.gov.mn/ цахим сайт, албаны дундын групп-т тус тус байршуулж, албан хаагчдад танилцуулж ажиллалаа.<br>➢ Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөл, Төрийн албаны зөвлөлтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр 2 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад албаны дарга, ёс зүйн дэд хорооны дарга, гишүүн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нар танхимаар, бусад албан хаагчид цахимаар хамрагдсан.<br>➢ 2024 оны эхний хагас жилийн байдлаар төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэл ирээгүй болно.<br>➢ "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам", "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг 6-р сард зохион байгуулж ажиллана.<br>➢ 2024 оны эхний хагас жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь гаргаж, ХШҮХМ-д хүргүүлсэн. | |
| 6 | Журам шинэчлэн батлах тухай 2016-01-11 №29 | Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 8 дугаар зүйл 8.5-д /Төсвийн ерөнхийлөн захирагч | Шилэн дансны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 29 дугаар тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Журамд заасан мэдээллүүдийг хуулийн хугацаанд иж бүрэн үнэн зөв байршуулсан эсэхэд дотоод аудит гүйцэтгэн, үр дүнг аймгийн дотоод аудитын хороонд тайлагнаж, улирал | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | (дотоод аудитын алба) нь Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана/ | бүр Монгол Улсын Сангийн яамны Санхүүгийн хяналт Эрсдлийн удирдлагын газарт хүргүүлэн ажиллаж байна. | |
| 7 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 2021.12.14 №64 | 14.5.2 Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрсдэлд суурилан зайлшгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийх, хяналт шалгалтыг цахим хэлбэрээр хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, бүх шатны Засаг дарга нарт даалгав. | Тайлант хугацаанд төлөвлөгөөт бус **2** удаагийн хяналт шалгалт хийгдлээ.<br>**1.** Аймгийн ЗДТГ-н Хууль, эрх зүйн хэлтсээс манай албанд цохож ирүүлсэн иргэн Б.Нямжаргалын өргөдөл гомдлын дагуу аймгийн Засаг даргын орлогчийн баталсан 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05/24 тоот “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт” хийх удирдамжийн дагуу Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2023 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт<br>**2.** Сангийн Сайдын баталсан 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн СХШХ/03 дугаар “ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН ХАРЬЯА ГААЛИЙН ГАЗАР, ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН НЭГДСЭН УДИРДАМЖ”, аймгийн Засаг даргын орлогчийн баталсан 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 17/24 дугаар удирдамжийн дагуу “Орхон аймаг дахь Гаалийн газар”-ын 2022, 2023 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг тус тус гүйцэтгэлээ. | 100% |
| 8 | | 14.5.3 Төрийн хяналт шалгалтын нөхцөл байдал, түүнийг хөнгөвчлөх арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чиглэсэн хяналт шалгалтыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 50 хувиар | Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хувьцаат компани болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх 2024 оны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулсан бөгөөд тус онд нийт 60 байгууллагад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх бөгөөд үүний 32 байгууллагад дотоод аудит гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.<br>Эхний хагас жилд иргэн, аж ахуй нэгжид чиглэсэн хяналт шалгалт хийгдээгүй болно. Цаашид заалтын хэрэгжилтийг ханган ажиллана. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | | бууруулах чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг төлөвлөж, хэрэгжүүлэхийг Засгийн газрын хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, бүх шатны Засаг дарга нарт даалгаж, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-нд зөвлөв. | | |
| 9 | Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол /Журам батлах тухай 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 159 дугаар тогтоол/ | Өмч хамгаалах байнгын зөвлөл ажиллах. | Байгууллагын даргын 2022 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн А/02 дугаар тушаалаар өмч хамгаалах зөвлөлийг 3 гишүүний бүрэлдэхүүнтэй томилсон. Өмч хамгаалах зөвлөлөөс байгууллагын эд хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад байнгын тогтмол хяналтыг тавин ажиллаж байна. | 100% |
| | Хуралдааны тэмдэглэл 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 02 дугаар тэмдэглэл | **Заалт-1.2:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагуудын шилэн дансны ашиглалт, хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүн, тайланг улирал бүр Ажлын албанд ирүүлэх, мөн тухайн дүнг танилцуулах хэлбэрийг өөрчилж, байгууллагуудын удирдлагуудыг хамруулан зохион байгуулдаг болох, шилэн дансны хэрэгжилтийн талаарх | ***Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд:***<br>➢ Шилэн дансны тухай хуулийн 2024 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайланг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд хүргүүлж ажиллалаа.<br>**Оны эхний хагас жилд:**<br>➢ “Цахим системийн шинэчлэл, мэдээлэл байршуулахад анхаарах зарим асуудал сэдэв”-т сургалтыг цахимаар зохион байгуулж, Сургалтад Орон нутгийн өмчит төсөвт байгууллага, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Орон нутгийн өмчит хувьцаат компани, Орон нутгийн тусгай сан, аймаг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг нийт 84 байгууллагын 50 мэдээлэл оруулагч, нягтлан бодогчид хамрагдлаа.<br>➢ Оюу цэцэрлэг, Жаргалант сумын Эрүүл мэндийн төв, 16 дугаар сургууль, 18 дугаар цэцэрлэг, Уран эгшиг сургааль зэрэг байгууллагуудын ***5*** нягтлан бодогчид ажлын байранд, ***24*** | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | мэдээ мэдээллийг иргэдэд сурталчлах ажлыг эрчимжүүлж, тогтмолжуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2023 оны 01 дүгээр сард багтаан Ажлын албанд ирүүлэх | байгууллагын нягтлан бодогчид утсаар болон зөвлөгөө, мэдээллийг өгч арга зүйгээр хангаж ажиллалаа.<br>➢ ***Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээ мэдээллийг иргэдэд сурталчлах ажлыг эрчимжүүлж, тогтмолжуулах зэрэг ажлуудыг зохион байгуулах гэсэн үүрэг даалгаврын хүрээнд:***<br>➢ Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, мэдээлэл оруулагч нарт ***Шилэн дансны нэгдсэн цахим хуудас-СХДАА***, ***Орхон Төрийн сан*** зэрэг цахим хуудсаар дамжуулан Шилэн дансны цахим системийн шинэчлэл, мэдээлэл байршуулалттай холбоотой 8 удаагийн зөвлөгөө, мэдээллийг хүргэж ажиллалаа. Мөн албаны ***www.Sankhuu.audit.or.gov.mn*** сайтад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хийгдсэн дотоод аудитын мэдээллийг тогтмол байршуулж байна.<br>➢ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн 2023 оны нэгдсэн дотоод аудитын дүн, мэдээг Орон нутгийн Тусгал телевизээр 1 удаа иргэд, олон нийтэд хүргэсэн.<br>Орхон аймгийн ЗДТГ-н Хууль, эрхзүйн хэлтэс орон нутгийн Номин телевизтэй хамтран явуулдаг “Хуулийн цаг” нэвтрүүлэгт оролцон мэдээлэл хүргэсэн. | |
| | Журам батлах тухай 2017 оны 04 дүгээр сарын 28 – ны өдрийн 49 дугаар тогтоол | Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах. | Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 71,72,73 дугаар зүйл, Засгийн газрын 2020оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 9 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 64 дүгээр тогтоол, Албаны даргын тушаалаар тооллогын комиссыг томилж, эхний хагас жилийн тооллогыг хийж дутагдсан, эвдэрсэн хөрөнгө байгаагүй бөгөөд энэ онд элэгдлийн хугацаа дуусч ашиглалтаас хасах хөрөнгө байхгүй болно. | 100% |
| | Аймгийн засаг даргын захирамж | “Албаны дүрэм, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх журам” | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | /2018 оны А/233 дугаар захирамж/ | | | |
| | Монгол улсын сангийн сайд орхон аймгийн засаг даргатай хамтран ажиллах гэрээний 3.37, 3.38 3.39, 3.40, 4.2 заалтууд хамраална. | 3.38. “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас аймгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, биелэлтийг улирал бүрийн эцэст Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж ажиллана.” заалт | “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу эхний хагас жилийн тоон мэдээ, бичмэл тайланг 2024 оны 07 дугаар 10-ны өдрийн дотор Монгол Улсын Сангийн яамны санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна. | 100% |
| | | 3.38. “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дотоод аудиторуудыг дотоод аудитын чиглэлээр сургаж, мэргэшүүлэх, дадлагажуулна.” заалт | Албаны Нэгдсэн менежментийн тогтолцоонд Чанарын дотоод аудит гүйцэтгэх Чанарын Дотоод аудитораар 1 албан хаагчийг даргын тушаалаар томилсон. Стандартын шаардлагын хүрээнд Чанарын Дотоод аудитор нь “Менежментийн тогтолцооны аудитын заавар” MNS ISO 19011:2020 стандартын сургалтад хамрагдан гэрчилгээ авсан байхыг шаарддаг.<br>Энэ хүрээнд Стандарт хэмжил зүйн газрын Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын үндэсний төвөөс зохион байгуулсан “MNS ISO 19011:2020 Менежментийн тогтолцоонд аудит явуулах заавар” стандартын сургалтад Чанарын Дотоод аудиторыг хамрууллаа.<br>Тус сургалтын зорилго нь “Байгууллагын менежментийн тогтолцоонд дүн шинжилгээ хийх, байнгын сайжруулалт хийхийн тулд дотоод аудитыг төлөвлөх, аудитын шалгуур бодит нотолгоог цуглуулах, үл тохирлыг илрүүлэх, холбогдох арга хэмжээг авах, аудитыг тайлагнах, арга зүйн заавраар хангах аудитын арга техникийг шинэчлэгдсэн стандартын гүйцэтгэх мэдлэг чадварын олгох юм. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Монголын Мэргэшсэн Нягтлан бодогчдын Институтээс 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрүүдийн хооронд зохион байгуулсан 120 цагийн “Аудиторын сургалт”-д 1 Дотоод аудитор хамрагдан амжилттай суралцаж, №1776 дугаартай гэрчилгээ авсан. | |
| | | 3.39. “Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн дагуу үйл ажиллагаа явуулж, хорооны хурлаар шийдвэрлэсэн асуудал, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” заалт | Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоода аудитын дүрмийн 7 дугаар зүйл, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 4.1.4 дэх заалтын хэрэгжилтийг хангаж, Аймгийн Дотоод аудитын хорооны хурлыг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.<br>Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хорооны даргаар батлуулан, дараах 4 асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэлээ. Үүнд:<br>1. 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт, 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт,<br>2. Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын тайлан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (2023 он, 2024 оны I улирал)<br>3. Монгол улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор байгууллагын нэршил өөрчлөгдсөн, Сангийн сайдын 268 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ыг шинээр баталсантай холбоотойгоор Аймгийн Засаг даргын 2018 оны А/233 дугаар захирамжаар баталсан “Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрэм”, Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх журам”-д орсон нэмэлт өөрчлөлтийг төслөөр тусган хэлэлцүүлэх, батлуулах;<br>4. Бусад асуудал (2023 онд хийсэн онцлох ажлууд)<br>Хорооны хурлаар нэмэлт өөрлчлөлт оруулсан “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм”, “Санхүүгийн хяналт шалгалт хийх журам”, Дотоод аудит хийх журам”-ын төслийг гишүүдийн 100%-ийн саналаар дэмжин Аймгийн Дотоод аудитын хорооны хурлын 01/24 дүгээр | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | тогтоолоор “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм”, “Дотоод аудит хийх журам”, “Санхүүгийн хяналт шалгалт хийх журам”-ыг тус тус батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж байна. | |
| | | 3.40. “Дотоод аудитын нэгдсэн системийг нэвтрүүлэх, дотоод аудит санхүүгийн хяналт, шалгалтын үйл ажиллагааг цахимд шилжүүлэх, шаардагдах тоног төхөөрөмжийг сайжруулах зэрэгт дэмжлэг үзүүлж ажиллана.” заалт | 2024 онд Монгол Улсын Сангийн Яамнаас улсын салбарын дотоод аудитын үйл ажиллагааг Олон улсын шилдэг туршлага, нийтлэг практикт нийцүүлэх, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор улсын салбарын бусад мэдээллийн системтэй уялдсан, вебд суурилсан Дотоод аудитын удирдлагын мэдээллийн системийг үе шаттай хөгжүүлэн нэвтрүүлж эхэлсэн.<br>Аймаг, нийслэл, дүүргүүдийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Дотоод аудит, Санхүүгийн хяналт шалгалтын жилийн төлөвлөгөө, тайлан, танилцуулга, ажлын баримтууд, засаглал, эрсдэл, дотоод хяналтын удирдлагын бүхий л мэдээллийг уг системд иж бүрэн байршуулж ажиллах үүрэг хүлээн ажилладаг.<br>Дээрх үйл ажиллагааг Сангийн сайд Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.40-д “дотоод аудитын нэгдсэн системийг нэвтрүүлэх, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахим системд шилжүүлэх, шаардагдах тоног төхөөрөмжийг сайжруулах зэрэгт дэмжлэг үзүүлэн ажиллана” гэж заасан. Тус заалтын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст албанд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг бэлтгэн 2024 оны 04 дүгээр сард 47 дугаартай албан бичгээр, Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газарт тус тус хүсэлтийг хүргүүлсэн.<br>Албаны хэмжээнд удирдлагын түвшинд 1,895.0 мянган төгрөгийн төсвийг шийдвэрлэн суурийн комьпютерийн 2 ш дэлгэц, 1 ш олон үйлдэлт өнгөт принтерийг худалдан авч, албан хаагчдын ажил үүргээ хурдан шуурхай гүйцэтгэх нөхцөлийг сайжруулж, байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж ажилласан.<br>Албанд бүртгэлтэй, албан хаагчдын ашиглаж буй комьпютер, тоног төхөөрөмжүүд нь ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул 2025 оны “Төсвийн төсөл”-д 46,333.2 мянган төгрөгийн төсвийг нэмж тусган хүргүүлж ажилласан. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 4.2. “Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана” | Сангийн сайд Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 4 дүгээр бүлгийн 4.2-т “Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана” гэсэн заалт, 2024 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тус тус хангах “**Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сан”**-ийн 2023 оны санхүү, үйл ажиллагаанд Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Дотоод аудитын олон улсын стандартын дагуу төлөвлөгөөт дотоод аудитыг Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр баталсан №24/24 дугаартай Дотоод аудитын удирдамжийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.<br>Дотоод аудитаар Жаргалант сумын Иргэдийн төлөлөгчдийн хурлаар Багуудын Иргэдийн Нийтийн хурлаас ирүүлсэн саналыг эрэмбэлэн 2023 онд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, 80%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.<br>Энэ удаагийн дотоод аудитаар сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Болзошгүй аваарын зардал” гэж хуваарилан хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт болон орон нутгийн иргэдийн саналын эрэмбэд ороогүй дараах 12 ажлын гүйцэтгэлд нийт 209,009.4 мянган төгрөгөөр зарцуулсан, 2023 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд иж бүрэн мэдээлээгүй, Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах жилийн ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, удирдамжгүйгээр хяналт шалгалтыг зохион байгуулсан зэрэг 3 зөрчил илэрсэн тул тус сангийн 2023 оны үйл ажиллагааг “Сайжруулах шаардлагатай” гэж дүгнэн Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн 1 албан шаардлага, ажил сайжруулах 3 зөвлөмж хүргүүлэн биелэлтийг тооцож ажилласан байна.<br>Мөн байгууллагын “засаглал”-ын төлөвшлийг 3 дугаар төвшин буюу “томьёолсон” түвшинд, “эрсдэлийн удирдлага”, “дотоод хяналт”-ын үйл | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | явцын төлөвшлийг 2 дугаар түвшин буюу "давтамжтай" түвшинд байна гэж дүгнэн цаашид аудитаар илэрсэн асуудалд анхаарч, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хэрэгжилтийг ханган ажиллах, хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд иж бүрэн байршуулах, иргэд, олон нийтийг бодит, үнэн зөв мэдээллээр хангах, дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг удирдлага, албан хаагчдад танилцуулж хэвших, дотоод хяналт, хяналт шинжилгээ үнэлгээний чиг үүргийг тус тусад нь хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөсөн байна. | |
| | | | **Биелэлтийн хувь:** | **100%** |
| **2.3.ХАРИЛЦАГЧ СУБЪЕКТТАЙ ЧИГ ҮҮРГИЙН ХАМААРЛЫН ХҮРЭЭНД:** | | | | |
| | Төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг дарга | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж гүйцэтгэх | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж байна. Үүнд:<br>➢ Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. "Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх", 14.2.10 "Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" заалт, Тус хуулийн 69 дүгээр зүйл. "Дотоод аудит". 69.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна." гэсэн заалтуудын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| | Сангийн яам, Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар, Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс | Байгууллагын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тоон тайлан, мэдээ, төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр хүргүүлэх, мөн СХШУБ-ийн эрх олгох, СХШУАБ, СХШУБ, Дотоод | Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, 69.2 дахь заалтаар "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хanган ажиллаж байна. Байгууллагын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тоон тайлан, мэдээ, төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр Сангийн яамны эрсдэлийн | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | аудиторуудыг сургалт, мэдээ мэдээллээр хангах | удирдлагын газарт, Сангийн сайд, Орхон аймгийн Засаг даргын 2024 онд хамтран ажиллах<br>гэрээний эхний хагас жилийн биелэлтийг холбогдох газруудад хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан. | |
| | Аймгийн Дотоод аудитын хороо | Дотоод аудитын хорооны нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, түүний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайланг хэлэлцэн шийдвэрлэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх. | Аймгийн Дотоод аудитын хорооны хурлыг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан. Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хорооны даргаар батлуулан, дараах 4 асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэлээ. Үүнд:<br>- 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт, 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт,<br>- Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын тайлан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (2023 он, 2024 оны I улирал)<br>- Монгол улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор байгууллагын нэршил өөрчлөгдсөн, Сангийн сайдын 268 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ыг шинээр баталсантай холбоотойгоор Аймгийн Засаг даргын 2018 оны А/233 дугаар захирамжаар баталсан “Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрэм”, Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх журам”-д орсон нэмэлт өөрчлөлтийг төслөөр тусган хэлэлцүүлэх, батлуулах;<br>- Бусад асуудал (2023 онд хийсэн онцлох ажлууд)<br><br>Хорооны хурлаар нэмэлт өөрлчлөлт оруулсан “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм”, “Санхүүгийн хяналт шалгалт хийх журам”, Дотоод аудит хийх журам”-ын төслийг гишүүдийн 100%-ийн саналаар дэмжин Аймгийн Дотоод аудитын хорооны хурлын 01/24 дүгээр тогтоолоор “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм”, “Дотоод | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | аудит хийх журам", "Санхүүгийн хяналт шалгалт хийх журам"-ыг тус тус батлан үйл ажиллагаандаа мөрдөж байна. | |
| | Аймгийн Засаг даргын Тамгын газар, хэлтэс, газар, агентлаг | Удирдах дээд байгууллагын шийдвэрийн хэрэгжилт, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах. | Оны эхний хагас жилийн байдлаар удирдах дээд байгууллагаас 150 албан бичиг ирснээ 51 нь хариутай бичиг ирсэн. Хариутай ирсэн бичгийг холбогдох заасан хугацаанд хүргүүлж ажилласан. Хугацаа хэтэрсэн болон шийдвэрлээгүй албан бичиг байхгүй. | 100% |
| | Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөл | Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог нөхөх, хүний нөөц болон бусад мэргэшүүлэх сургалтад хамрагдах. | Энэ онд Төрийн захиргааны 2 албан тушаалд сул орон тоо гарсан байна.<br>1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн<br>2. Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч<br>Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах боломжийг хангах үүднээс шилжүүлэн авч ажиллуулах зарыг "Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөл"-д хүргүүлж ажилласнаар тус салбар зөвлөл хуульд заасан хугацаанд "Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай" зарыг https://erdenet.mn/- сайтад байршуулсан. Манай алба тус зарыг өөрийн байгууллагын https://sankhuu.orkhon.gov.mn/- сайтдаа байршуулж ажилласан.<br>➢ Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн албан тушаалын зарыг 2024.05.28-ны өдрөөс 2024.06.05-ны өдрийн 17:00 цаг хүртэл материал хүлээн авахад Баян-Өндөр сумын ЗДТГ-т Худалдан авах ажиллагаа, өмч хариуцсан мэргэжилтэн П.Даваажаргал шилжин ажиллах хүсэлт, холбогдох материалыг ирүүлсэн.<br>➢ Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч албан тушаалын зарыг 2024.08.28-ны өдрөөс 2024.09.02-ны өдрийн 17:00 цаг хүртэл материал хүлээн авахад Булган аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | албан тушаалтай П.Азхишиг шилжин ажиллах хүсэлт, холбогдох материалыг ирүүлсэн.<br>Тус 2 албан тушаалд ажиллах хүсэлт гаргасан албан хаагчдын материалтай танилцаж, шаардлага хангасан тул 2 албан тушаалтны шилжүүлэн авч ажиллуулсан.<br>“Төрийн албаны салбар зөвлөл”-өөс зохион байгуулсан дараах сургалтуудад албан хаагчид цахимаар хамрагдсан. Үүнд:<br>✓ Төрийн албачн хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн танилцуулга- 2024.03.07<br>✓ “Дижитал шилжилт, Виртуал орчинд ажиллах”-2024.03.14<br>✓ Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-II” сэдэвт сургалт – 2024.03.28<br>✓ Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан “Төрийн албаны шинэчлэл: Шинэ 30 жил” сэдэвт сургалт- 2024.09.02<br>✓ “ТАЦНС-н шинэ хөгжүүлэлттэй холбоотой дэмжлэг үзүүлэх” сэдэвт сургалт-2024.09.05<br>✓ “Гадаад улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж үр дүн” сэдэвт сургалт- 2024.09.12<br>✓ "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн эхний үе шат "Шинэ сэргэлтийн бодлого" богино хугацааны сургалтад 10 албан хаагч цахимаар болон танхимаар 100% хамрагдаж гэрчилгээ авсан.<br>Мөн Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөл, Төрийн албаны зөвлөлтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр 2 удаагийн сургалтыг зохион байгуулж уг сургалтад Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэг Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, ТАЗ-ийн ССМНСГ-ын хэлтсийн дарга С.Батнасан, ТАЗ-ийн МХШГ-ын ахлах референт Р.Жавзандулам нар мэдээлэл өгсөн. | |
| | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын | Төсвийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус | 2024 оны Дотоод аудит, СХШ-н төлөвлөгөөгөөр 61 байгууллага шалгахаас эхний хагас жилд 34 байгууллага шалгасан буюу төлөвлөгөөний гүйцэтгэл 56%-тай байна. Дотоод аудитаар 19 | 100% |

<table>
<tr><td></td><td>хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд</td><td>дотоод аудит болон санхүүгийн хяналт шалгалт хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах, гарсан зөрчлийг арилгуулах</td><td>байгууллага, Санхүүгийн хяналт шалгалтаар 15 байгууллагын шалгалтад хамруулсан байна. Хяналт шалгалт гүйцэтгэсэн 34 байгууллагуудад эрсдлийн үнэлгээг хийхэд Их эрсдэлтэй-1, Дунд эрсдэлтэй-15, бага эрсдэлтэй-18 гэж үнэлэгдсэн байна.<br>2024 оны дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2 улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит, 17 байгууллагад дотоод аудитыг Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын секторын дотоод аудитын аргачлал”-ын дагуу, 15 байгууллагад санхүүгийн хяналт шалгалтыг Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх стандарт”-ын дагуу тус тус гүйцэтгэн албаны даргын тушаалаар баталсан “Эрсдэлийн менежментийн журам”-аар эрсдэлийг үнэлэн зөвлөгөө өгч, нөхөн төлбөрийн акт, зөрчил таслан зогсоох албан шаардлага, ажил сайжруулах зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.<br>➢ Дотоод аудит, хяналт шалгалтын төрөл<br><table><tr><td rowspan="2">Хяналт шалгалт, дотоод аудитад хамрагдсан байгууллагын тоо</td><td colspan="2">Шалгалтын төрөл</td><td colspan="2">Шалгалтын хэлбэр</td></tr><tr><td>Төлөвлөгөөт</td><td>Төлөвлөгөөт бус</td><td>Дотоод аудит</td><td>СХШ</td></tr><tr><td>34</td><td>32</td><td>2</td><td>19</td><td>15</td></tr></table><br>2024 оны эхний хагас жилийн байдлаар Улсын төсөвт үйлдвэрийн газар-1, Төсвийн байгууллага-27, ОНӨААТҮГ-3, Засгийн газрын тусгай сан-1, Бусад /ТБ/-2 нийт 34 байгууллагад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэсэн бөгөөд “Хангалттай” үнэлэгдсэн 6 байгууллага, “Хангалттай бус” үнэлэгдсэн 11 байгууллага, “Сайжруулах шаардлагатай” үнэлэгдсэн 14 байгууллага байна. Төлөвлөгөөт бусаар гүйцэтгэсэн 1 шалгалтад зөрчлийг танилцуулж ажилласан байна.</td><td></td></tr>
<tr><td></td><td>Иргэн, олон нийтийн байгууллага,</td><td>Өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх, шилжүүлэх</td><td></td><td>100%</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | холбогдох бусад байгууллагууд | | 2024 оны эхний хагас жилийн байдлаа албаны хэмжээнд 21 өргөдөл хүсэлт ирсэн байна. Үүнд:<br>➢ Албан хаагчдаас ирсэн-17<br>➢ Албанд гаднаас ирсэн-4 байна.<br>Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт хуулийн хугацаанд 100% шийдвэрлэсэн. Албан хаагчдаас болон албанд хандсан гомдол санал ирээгүй. | |
| | | | | **100%** |
| | | | | **100%** |